



МОНГОЛ УЛС
ХОВД АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 07 сарын 17 өдөр

Дугаар А/452

Ховд

Ажил сайжруулахыг үүрэг болгож,
сахилгын шийтгэл ногдуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.6-ийн “а”, Төрийн албаны тухай хууль /шинэчилсэн найруулга/-ийн 4 дүгээр зүйлийн 4.1, 48 дугаар зүйлийн 48.1.2, аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 9 дүгээр хуралдааны 9/04 дүгээр тогтоолын 2.6 дахь заалт, аймгийн Төрийн аудитын газрын төсвийн ерөнхийлөн захирагчийн 2018 оны санхүүгийн нэгэтгэсэн тайланд хийсэн санхүүгийн аудитын тайланг тус, тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар харьяа байгууллагууд нь хязгаарлалттай дүгнэлттэй Алтай сумын Засаг дарга Б.Энхбаяр, Булган сумын Засаг дарга Б.Амгаланбадрах, Дарви сумын Засаг дарга О.Ганцоож, Дуут сумын Засаг дарга А.Энхбаяр, Зэрэг сумын Засаг дарга Д.Октябрь, Мөнххайрхан сумын Засаг дарга Б.Батболд, Мөст сумын Засаг дарга Б.Сугарбат, Үенч сумын Засаг дарга Т.Батсүх, Ховд сумын Засаг дарга Ш.Ерболат, Чандмань сумын Засаг дарга Б.Галбадрах, Эрдэнэбүрэн сумын Засаг дарга У.Цэрэнтогтох, Жаргалант сумын Засаг дарга Ц.Ганданповрон, аймгийн Байгаль орчин, аялал жуулчлалын газрын дарга Л.Батбаяр нарт аудитын байгууллагаас өгөгдсөн үүрэг даалгаврыг хангаж бүртгэл, санхүүгийн ажлаа эрс сайжруулах арга хэмжээ авч ажил хариуцсан ажилтнуудын хариуцлагыг дээшлүүлж ажиллахыг үүрэг болгосугай.


2. 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайлангаар сумын нэгдсэн тайлан болон 2 байгууллага хязгаарлалттай, 1 байгууллага татгалзсан дүгнэлттэй гарсан Манхан сумын Засаг дарга П.Мөнхбатын албан тушаалын 3 сарын цалинг 10.0 хувиар, сумын 2 байгууллага хязгаарлалттай, сумын нэгдсэн тайлан болон 3 байгууллага сөрөг дүгнэлттэй Цэцэг сумын Засаг дарга Ж.Мөнхзоригийн албан тушаалын 3 сарын цалинг 15,0 хувиар бууруулах сахилгын шийтгэлийг тус, тус ногдуулсугай.

3. 2018 оны төсвийн гүйцэтгэлийн тайланд аудитын байгууллагаас хязгаарлалттай, дүгнэлт авсан сумдын санхүүгийн албаны дарга, байгууллагуудын төсвийн захирагч, ахлах нягтлан бодогч нарт ажил сайжруулах хугацаатай үүрэг даалгавар өгч биелэлтийг ханган, сөрөг болон татгалзсан дүгнэлт авсан албан тушаалтануудад холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага тооцож дүнг 2019 оны 07 дугаар сарын 31-ний өдрийн дотор аймгийн Засаг даргын Тамгын газрын Санхүү, төрийн сангийн хэлтэст ирүүлэхийг сумдын Засаг дарга, төсвийн захирагч нарт үүрэг болгосугай.

4. Төсвийн тухай хууль болон бусад холбогдох хууль, тогтоомжийн биелэлтийг хангаж, аудитын байгууллагын зөвлөмжийг хэрэгжүүлэн тогтоосон актын төлбөр, албан шаардлагыг биелүүлэн өр, авлагыг бууруулж санхүүгийн сахилгыг чанд сахин ажиллахыг нийт сумдын Засаг дарга, төсвийн захирагч нарт тус, тус үүрэг болгосугай.

5. Тус захирамжийн биелэлтийг хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга /Д.Энхболд/-д даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



Б.ДҮГЭРЖАВ

